



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/611

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс  
томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 44 дүгээр тушаалын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын Захиргааны барилгын гадна тохижилтын ажил ИНЕГ/УТ/ТББ/А-05/18 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Б.Ганхуяг

Нисэх буудлуудын удирдах газрын  
Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

П.Сүхболд

Худалдан авах ажиллагааны тасгийн  
аэродромын инженер

Гишүүд:

Г.Мөнхболд

Нисэх буудлуудын удирдах газрын  
Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах  
мэргэжилтэн

Г.Энхчулуун

Улаанбаатар хотын Олон улсын шинэ  
нисэх буудлын ашиглалтын өмнөх  
захиргааны албаны захиргаа, хүний  
нөөцийн менежер

Э.Мөнх-Эрдэнэ

Улаанбаатар хотын Олон улсын шинэ  
нисэх буудлын ашиглалтын өмнөх  
захиргааны албаны аэродромын  
ашиглалтын инженер


Я.Пагмаажав

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн Зам, тээвэр,  
мэдээлэл холбооны асуудал хариуцсан  
бодлогын мэргэжилтэн /Тохиролцсоноор/

С.Эрдэнэцогт

Төв аймгийн Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн  
/Тохиролцсоноор/

2. Дээрх ажлыг гэрээнд заасан тоо хэмжээ, ажлын даалгавар болон зураг төслийн дагуу шалган, хүлээн авах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Худалдан авах ажиллагааны тасагт хүргүүлэхийг Комиссын дарга /Б.Ганхуяг/-д даалгасугай.

ДАРГА  Л.БЯМБАСҮРЭН